



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны ... сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.16 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн цахим мэдээллийн нэгдсэн санг ажиллуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайд Ч.Номин нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦИ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ҮНИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь эм, эмнэлгийн хэрэгслийг импорт болон дотоодын үйлдвэрийн үнээс эхлэн эцсийн хэрэглэгч хүртэлх бодит цаг хугацаанд суурь үнэ, бөөний үнэ, жижиглэнгийн үнийг цувралын дугаар, тоо ширхэг, байршил бүрээр Цахим мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, ашиглах, үлдэгдэл нөөцөд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журмын үйлчлэлд тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, эрүүл мэндийн байгууллага, Гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хангамжийн байгууллагын систем хөгжүүлэгч байгууллага, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж хөгжүүлэгч байгууллага, цахим мэдээллийн нэгдсэн сан ашиглах, хяналт тавихад оролцох төрийн болон хувийн хэвшлийн байгууллага хамаарна.

1.3 Цахим мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нь ил тод, мөшгих боломжтой, мэдээллийг эх сурвалжаас нэг л удаа цуглуулж, системүүд хоорондын автомат мэдээлэл солилцоо (API, ERP интеграци)-гоор дамжуулах, төрийн мэдээллийн бусад системтэй уялдаатай, давхардалгүй байх; мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хуульд заасны дагуу хамгаалах зарчмыг баримтална.

Хоёр. Нэр томьёо

2.1 "Цахим мэдээллийн нэгдсэн сан" гэж эм, эмнэлгийн хэрэгслийн цуврал болон үнэ, үлдэгдлийн мэдээллийг үйлдвэрлэсэн болон импортолсон, борлуулсан, устгалд оруулсан байгууллага, салбар, байршил тус бүрээр бодит хугацаанд бүртгэж, хадгалж, харьцуулж, эрх бүхий байгууллага, олон нийтэд мэдээлдэг нэгдсэн (цаашид "цахим сан" гэх) систем;

2.2 "Мэдээлэл нийлүүлэгч байгууллага" гэж цахим санд мэдээллийг тогтмол нийлүүлэх үүрэг бүхий Гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хангамжийн байгууллага, эрүүл мэндийн байгууллагыг;

2.3 "Мэдээлэл дамжуулагч байгууллага" гэж цахим санд мэдээллийг тогтмол дамжуулах үүрэг бүхий хангамжийн байгууллагын систем хөгжүүлэгч байгууллага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж хөгжүүлэгч байгууллагыг;

2.4 "Цахим санг хариуцагч" гэж Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа эрүүл мэндийн салбарын мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага буюу Эрүүл мэндийн хөгжлийн төвийг;

2.5 "Агентлаг" гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг;

Гурав. Цахим санд бүртгэх, үнэ тогтоох

3.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47.13, 47.14, 47.15-д заасны дагуу энэ журмын 2.2, 2.3-т заасан байгууллагаас ирүүлсэн мэдээллийг тухай бүр худалдааны нэршил, олон улсын нэршил, бүртгэлийн дугаар, савлалт, тун хэмжээ, цувралын дугаар зэрэг кодоор ялгаж бүртгэх бөгөөд ижил бүтээгдэхүүний өөр өөр цувралын суурь үнэ ялгаатай байж болохыг харгалзан цахим санд API сервисээр бүртгэнэ.

3.2 Агентлаг бөөний болон жижиглэнгийн үнийг сард 2 удаа татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээллийн системд бүртгэгдсэн борлуулалтын мэдээлэлтэй тулгаж, үнэн зөвийг магадалж болно.

3.3 Дотоодод үйлдвэрлэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн суурь үнийг үйлдвэрээс гарч буй үнээр тогтоож, үйлдвэрлэгч байгууллага Агентлагт бүртгүүлэн цахим санд оруулна.

3.4 Импортоор орж ирэх эм, эмнэлгийн хэрэгслийн суурь үнийг гаалийн мэдүүлгээр тодорхойлсон гаалийн үнэ дээр ногдуулсан гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварыг нэмж тогтооно. Гадаад валютаар илэрхийлэгдсэн үнийг Монголбанкны тухайн өдрийн албан ханшаар автоматаар төгрөгт хөрвүүлж бүртгэнэ

Дөрөв.Талуудын эрх, үүрэг

4.1 Мэдээлэл нийлүүлэгч нь тусгай зөвшөөрлийн чиглэлийн хүрээнд агентлагаас импортын мэдүүлэгийн хүсэлтэд хариу авах, агентлагаас гаргаж буй зар, мэдээлэлийг хүлээж авах эрхтэй.

4.2 Хангамжийн байгууллагууд нь эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан нийтлэг үүргийг мөрдөн ажиллана.

4.3 Мэдээлэл нийлүүлэгч байгууллага нь цахим санд нийлүүлсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

4.4 Мэдээлэл дамжуулагч байгууллага нь цахим цанг хариуцагчаас мэдээлэл дамжуулах эрх авах, API холболтын гарын авлага авах, мэдээлэл дамжуулах сервист алдаа гарвал мэдэгдэж засуулах эрхтэй.

4.5 Мэдээлэл дамжуулагч байгууллага нь мэдээлэл нийлүүлэгч байгууллагын бүртгэсэн мэдээллийг өөрчлөхгүйгээр тухай бүр дамжуулах үүрэгтэй.

4.6 Цахим санг хариуцагч нь агентлагаас цахим санд бүртгэгдсэн мэдээллийн үнэн зөвд хяналт тавихыг шаардах эрхтэй.

4.7 Цахим санг хариуцагч нь Төрийн болон албаны нууцын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль, эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудыг мөрдөн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангах үүрэгтэй.

4.8 Агентлаг нь мэдээлэл нийлүүлэгчээс эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд заасан мэдээллийг нийлүүлэх, мэдээллийн үнэн зөвийг хариуцахыг шаардах, шаардлага биелүүлэхгүй тохиолдолд хариуцлага тооцох эрхтэй.

4.9 Агентлаг нь цахим санд цугларсан мэдээлэлд хяналт тавих, Төрийн болон албаны нууцын тухай хуулийг дагаж мөрдөх, цахим санд бүртгэгдсэн мэдээллийг боловсруулан эрх бүхий байгууллагад мэдээлэл, тайлан гаргаж өгөх үүрэгтэй.